

ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ГАНЦ ХУВЬ БҮТЭЭЛ ХАДГАЛЖ БАЙГАА
ХУВИЙН НОМЫН САНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

(Төсөл)

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол улсын болон гадаад улсын хуулийн этгээд, төрийн бус байгууллага, иргэний хувийн номын санд түүх, соёл, шинжлэх ухааны чухал ач холбогдол бүхий ганц хувь бүтээл байгаа тохиолдолд тухайн номын санд дэмжлэг үзүүлэх, сурталчлах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Хувийн номын санд байгаа чухал ач холбогдол бүхий ганц хувь бүтээлийг хадгалж хамгаалахад үзүүлэх дэмжлэг

2.1. Түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах ном, судрыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх;

2.2. Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд орсон баримтат өвийг үндэсний болон бүс нутгийн, дэлхийн өвд бүртгүүлэх ажлыг ЮНЕСКО-гийн Үндэсний комисс, “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн үндэсний хороо хамтран зохион байгуулах;

2.3. Үндэсний болон нийтийн номын сан нь тухайн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй хувийн номын сантай хамтран ажиллаж, мэргэжил аргагүйн зөвлөгөө өгч, чухал ач холбогдол бүхий бүтээлийг сэлбэн засах ба сэргээн засварлахад туслалцаа үзүүлэх;

2.4. Аймаг, нийслэлийн төв номын сан нь учирч болзошгүй аюул нүүрлэсэн чухал, ганц хувь бүтээлд мэргэжлийн дүгнэлт гарган Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

2.5. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга нь устах, гэмтэх аюул учирч байгаа ном судрыг хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг орон нутгийн төсөв, сан болон бусад хандивын хөрөнгийн үндсэн дээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

Гурав. Хувийн номын сангийн чухал, ганц хувь бүтээлийг ашиглах, сурталчлахад үзүүлэх дэмжлэг

3.1. Үндэсний номын сан болон гадаад, дотоодын номын сан, музей, эрдэм шинжилгээний байгууллагаас хувийн номын сан дахь чухал ач холбогдол бүхий ганц хувь ном судрыг судлан, олон нийтэд сурталчлахад мэргэжлийн туслалцаа үзүүлэн хамтарч ажиллах;

3.2. Чухал ач холбогдол бүхий ганц хувь бүтээлийг цахим болон хуулбар хэлбэрээр уншуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор тоон хэлбэрт шилжүүлэхэд эзэмшигчийн хүсэлт, гэрээний үндсэн дээр хуулбарлах, цахим хэлбэрт оруулах ажлыг зохион байгуулах;

3.3. Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй ном судрын эх хувийг судалгаа шинжилгээний ажилд ашиглах тохиолдолд эзэмшигч, байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр ашиглуулна.

3.4. Хувийн номын сангийн чухал ач холбогдол бүхий ганц хувь бүтээлийг эзэмшигчтэй гэрээ байгуулсны үндсэн дээр баримтат кино, дүрс бичлэг, хэвлэмэл болон цахим хэлбэрээр нийтэд сурталчаах, эрдэм шинжилгээ судалгааны төсөл, үзэсгэлэн зохион байгуулахад хамтран ажиллах.

Дөрөв. Бусад

4.1. Энэхүү журамд хамаарах бүтээлд эрдэм шинжилгээний тодорхойлолт хийх, төрөлжүүлэн ангилах, Соёлын өвийн улсын бүртгэл мэдээллийн сан болон Үндэсний баримтат өвийн бүртгэл мэдээллийн санд бүртгүүлэх үүргийг эзэмшигч хүлээнэ.

4.2. Хувийн номын санд байгаа чухал ач холбогдол бүхий ганц хувь бүтээлийг ашиглах, хадгалж хамгаалах, бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлыг эзэмшигч, өмчлөгч бүрэн хариуцна.